

**“ДИСПЕТЧЕРИЙН ҮНДСЭНИЙ ТӨВ” ХХК-ИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛЭЭС**

2017 оны 06 дугаар сарын 28 өдөр

№04

Улаанбаатар хот

“Диспетчерийн үндэсний төв” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2017 оны 06 дугаар сарын 28-ний өдрийн хурлын тэмдэглэлд:

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Нэгдсэн сүлжээний 2016-2017 оны өвлийн их ачааллын горим ажиллагааны байдал.

ТЭМДЭГЛЭСЭН НЬ:

... Төвийн бүсийн ЦЭХ-ний нийт хэрэглээ түгээлтээр өвлийн горимын гүйцэтгэл төлөвлөгөөнөөс 6,39 сая кВт цаг буюу 0,25% -аар буурсан байна.

Импортын эрчим хүчийг хэмнэн, дотоодын үйлдвэрлэлтээ дэмжих зохицуулалт хийсний дүнд өвлийн горимын хугацаанд ДЦС-уудын түгээлт 0,9-2%-аар илүү түгээлттэй байна.

Өвлийн их ачааллын үед гарсан хүндрэлүүд:

- ИХБ 4-ийн автотрансформатор хэт ачаалагдах нөхцөл үүссэн.
- 12-р сард цахилгаан эрчим хүчний хэрэглээ төлөвлөснөөс 28 сая.кВт.ц-аар буурснаар үйлдвэрлэх ТЗЭ-ийн төлөвлөгөөг биелүүлэхэд хүндрэл гарлаа.
- Мөн дулааны хэрэглээ төлөвлөгөөнөөс буурч үйлдвэрлэлтийн төлөвлөгөө биелүүлэхэд хүндрэл гарсан.
- Мөрөн-Тэлмэнгийн шугам хамгаалалтаар тасарч байсан зэрэг асуудлууд байсан байна...гэж тэмдэглэжээ.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэгдсэн сүлжээний 2016-2017 оны өвлийн их ачааллын горим ажиллагааг “Хангалттай” гэж дүгнэж байна. Цаашид гүйцэтгэх захирал Д.Балдорж, тэргүүн дэд захирал бөгөөд ерөнхий диспетчер Л.Бөхболд нарт үүрэг болгох нь:

1. Өвлийн их ачааллын үед гарсан хүндрэлүүдийг дахин гаргуулахгүй байх талаар техник зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах,
2. Өвлийн их ачааллын үеийн цахилгаан, дулааны хэрэглээг оновчтой төлөвлөхөд анхаарч ажиллах,
3. 2017-2018 оны өвлийн бэлтгэл ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлэн, өвлийн их ачааллын горим төлөвлөлтийг судалгаа, шинжилгээний үндсэн дээр боловсруулан танилцуулах...гэжээ”.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Д.ЧИМЭДДОРЖ

